

Эрт цагт, жижиг хотод нэгэн аав хоёр хүүтэйгээ амьдардаг байжээ.

Аав нь хоёр хүүдээ хязгааргүй их хайртай байв.

Том хүү нь аавынхаа үгэнд сайн ордог дуулгавартай хүү байв.

Харин бага хүү нь зүгээр л тоглох дуртай дураараа нэгэн байв.

Тэгээд нэг өдөр бага хүү нь гэрээсээ холдвол юу хүссэнээ хийж чадна гэж бодсон тул гэрээсээ гарч ганцаараа амьдрахаар шийджээ.

Бага хүү нь аавруугаа ирээд ингэж хэлэв.

“Аваа, надад өвлөгдөж үлдэх хөрөнгийг түрүүлээд өгчих! Би гэрээсээ гарч ганцаараа амьдармаар байна.” гэж хэлэв.

Үүнийг сонссон аав нь хүүгээ явуулах талаар бодох төдийд сэтгэл нь өвдөж байв. Тэгээд бага хүүгийнхээ хүссэнээр хөрөнгөө хуваан өгч явуулав.

Аваасаа өвлөгдөх хөрөнгөө авсан бага хүү гэрээ орхин хол явав. Тэрээр том, эрээн мяраан зүйлээр дүүрэн хотод хүрч очоод шинээр найзалсан найзуудаа дуудаж амтат хоол идэж, үнэтэй усан үзмийн дарсанд ёроолгүй мэт мөнгөө үрсгаж байв.

Мөн тэрээр үнэтэй хувцас, үнэт эдлэл худалдан авч ханхүү шиг хувцаслав.

Гэвч эцэст нь тэрээр аваасаа авчирсан бүх мөнгөө үрэн таран хийчхэв.

Мөнгө нь дууссан бага хүүгийн хажууд хэн ч үлдэлгүй бүгд холдон одов. Харин тэрээр юу ч үгүй гар хоосон гуйлгачин болон хоцров.

Бага хүүгийн гэдэс нь өлсөөд тэвчилгүй нэгэн айлын зарцаар ажиллахаар болов.

Бага хүү нь үнэхээр хүнд хэцүү байсан учраас маш ихээр уйтгарлан гуниглаж байв.

Хамгийн хэцүү үеийг туулж байх үедээ бага хүү нь аавыгаа санагалзав.

Тэрээр аавыгаа маш их, бүр маш их санаж эхлэв.





Тэгээд бага хүү шийдэж, төрсөн нутаг руугаа буцахаар болов.
Аавынхаа байгаа төрсөн нутаг руугаа ойртох тусам бага хүү санаа зовж, айж эмээн, сэтгэл нь зовниж байв.
Бага хүү нь гуниглан үйлж төрсөн гэрийн зүг алхсаар байв.
Гэтэл тээр хол байгаа төрсөн гэрийнх нь хаалганы дэргэд байх аав нь харагдав.
Учир нь, аав нь гэрийнхээ хаалганы хажууд өдөр бүр бага хүүгээ эргэж ирэхийг нүдээ ширгэтэл хүлээдэг байв.
Тээр холоос ирэх гүйлгачин болчихсон бага хүүгээ хараад аав нь хүү рүүгээ хамаг хурдаараа гүйж очоод тэврэв.
Аав нь зарц нараа дуудан,
“Хурдан! Хамгийн сайн дээлийг авчирч миний хүүд өмсөг. Хуруунд нь бөгж, хөлд нь шаахай өмсөг.
Тэгээд тарган тугал гаргаж найр хийж бага хүү буцаж ирсэн баярыг тэмдэглэцгээе!” гэж хэлэв.
Аав нь том найр хийж хамтдаа хөгжилдөцгөөв.
Харин бага хүү нь аавынхаа агуу их хайрыг ингэж л ойлгосон юм.

- Дараах библийн эшлэлийг дуурайж бичээд цээжлээрэй. (Лук 15:32)

Алдагдсан боловч олдлоо.



Бүтээлч байцгаая 1. Өнөөдөр юу сурснаа сайн бодонгоо өнгөөр ялгаж будаарай.



Бүтээлч байцгаая 2. Доорх зургийг хайчилбараар нь хайчлаад өнөөдөр сурсан түүхийн дарааллын дагуу наагаарай.

1

2

3

4

5

6





Selah
Ministry of Christian Publishing

Нэр :